

ӨМНӨХ ҮГ

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Төв /СХҮТ/ нь Олон улсын стандартчиллын байгууллагын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд улсын стандартчиллын бодлогыг Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг юм.

Тус төв нь тухайн салбарын улсын стандартын төсөл боловсруулах ажлыг техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг. Техникийн хороогоор хэлэлцэж 75-аас доошгүй хувийн саналаар зөвшилцсөн стандартын төслийг Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөл /СХҮЗ/-ийн тогтоолоор баталсанаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Гамшгаас хамгаалах сургалт эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Галын Шинжилгээний Төвийн дарга, шадар ахмад Ш.Олзвой боловсруулан Аюулгүй байдлын стандартчиллын техникийн хороогоор хэлэлцэн зөвшилцөж, Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн тогтоолоор баталсан.

Стандартын анхны үзлэгийг 2008 онд, дараа нь 5 жил тутам хийнэ.

Ангилалын код 13.220

Гал түймрээс хамгаалах, Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм	MNS 5566:2005
Protection against fire Fire protection instrument for building technical requirements	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2005 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 77 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2006 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын норматив шаардлагыг заавал мөрдөнө.

1. Зорилго

Энэхүү стандартын зорилго нь гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй шаардлага, тухайн объектод ашиглаж буй бодис материалын тэсрэх, гал авалцах чанараас хамааруулан ирдэг, албан байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгжийн тоног төхөөрөмж, машин техник, барилга байгууламжид байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн төрөл, тоо хэмжээг тогтооход оршино.

2. Шаардлага ба хамрах хүрээ

Гал түймэр гарах магадлалын доод хэмжээ нь жилд 10 тохиолдлоос хэтрэхгүй байх ёстой, хэтэрсэн тохиолдолд гал түймэр гарах магадлалын түвшин өндөрсөнө. Ямар ч үйлдвэр, барилга байгууламжид галын аюулгүй байдлын түвшингээс үл хамаарах байгалийн зарим үзэгдэл, хүний санаатай болон санамсаргүй үйлдлийн улмаас гал түймэр гарах тохиолдол байдаг. Иймээс гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл нь аж ахуйн үйл ажиллагааны бүхий л салбарт зүйлшгүй байх шаардлагатай.

Энэхүү стандарт нь Монгол улсын газар нутаг дээр ашиглагдаж байгаа болон өргөтгөл, шинэчлэл, засвар үйлчилгээ хийж байгаа, шинээр ашиглалтад орох барилга байгууламж, тоног төхөөрөмж, автомашин, техникт хамаарна.

3. Норматив ишлэл

Энэ стандартад ишлэл хийсэн дараах стандарт, баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлээс иш татаж хэрэглэнэ. Үүнд:

3.1	MNS 4244-94	Галын аюулгүй байдлын ерөнхий шаардлага
3.2	MNS 639:89	Галын техник нэр томъёо, тодорхойлолт
3.3	MNS 640:89	Галын аюулгүй байдал. Нэр томъёо ба тодорхойлолт
3.4	MNS 641:86	Гал эсэргүйцэх техник, үндсэн төрөл, байрлал, үйлчилгээ
3.5	MNS 12.104:94	Тэсрэлтийн аюулгүй байдал, ерөнхий шаардлага
3.6	БНБД 31-04-03	Захиргаа аж ахуйн барилга
3.7	БНБД 21-01-02	Барилга байгууламжийн галын аюулгүй байдал
3.8	ПНБ 105-03	Определение категорий помещений, зданий и наружных установок по взрыво-пожарной и пожарной опасности

4. Нэр томьёо, тодорхойлолт

Энэ стандартад хэрэглэсэн нэр томьёог дараах байдлаар ойлгоно. Үүнд:

4.1 Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл

Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл нь гал үүсвэрлэн гарсан эхлэлийн үед шатлагыг зогсоох зориулалтаар хэрэглэх дараах төрлийн багаж хэрэгсэлээс бүрдэнэ. Үүнд:

1. Хүрз
2. Галын дэгээ
3. Хөрөө
4. Сүх
5. Царил
6. Хувин
7. Жоотуу
8. Элстэй сав /хайрцаг/
9. Устай сав /торх/
10. Эсгий болон галд тэсвэртэй бүтээлэг
11. Төрөл бүрийн гал унтраагуур
12. Агаар дахь тэсрэх болон галын аюултай хольцыг саармагжуулах бодис бүхий хэрэгсэл
13. Бусад /саармагжуулагч бодис, усан сан, ус сорох, шахах хөөрөг, галын хоолой, хошуу г.м./

4.2 Үйлдвэрлэлийн тэсрэх болон галын аюулын ангилал

Технологийн зориулалтаар ашиглагдаж буй бодис материалын тэсрэх болон галын аюулын шинж чанар, хадгалагдаж буй хэмжээгээр нь үйлдвэрлэлийг А,Б,В,Г,Д гэсэн ангилалд хуваана.

4.2.1 Ангилал А

Тэсрэх болон галын аюултай үйлдвэрлэл – Хий, уурын агаар дахь тэсрэх аюултай хамгийн бага хольц нь авалцан асах үедээ орчиндоо 5 кПа-аас дээш илүүдэл даралт /тооцоогоор/ үзүүлдэг, эгшин зуур авалцан асах температур нь 28⁰С-ээс ихгүй байдаг шатдаг хий, хялбар авалцан асах шингэн.

Өөр хоорондоо болон ус, агаар дахь хүчилтөрөгчтэй харилцан үйлчилсэнээс тэсрэх болон авалцан асах аюултай, тэсрэлтийн илүүдэл даралт нь 5 кПа-аас их байдаг бодис материал хэрэглэдэг үйлдвэрлэл.

4.2.2 Ангилал Б

Тэсрэх болон галын аюултай үйлдвэрлэл – Тоос, уурын агаар дахь тэсрэх аюултай хамгийн бага хольц нь авалцан асах үедээ орчиндоо 5 кПа-аас дээш илүүдэл даралт /тооцоогоор/ үзүүлдэг, эгшин зуур авалцан асах температур нь 28⁰С-ээс ихгүй байдаг шатамхай тоос, байгалийн гаралтай болон нийтлэг хөвөнлөг материал, хялбар авалцан асах шингэн хэрэглэдэг үйлдвэрлэл.

4.2.3 Ангилал В

Галын аюултай үйлдвэрлэл – Өөр хоорондоо болон ус, агаар дахь хүчилтөрөгчтэй харилцан үйлчилсэнээс зөвхөн гал гарах онцлогтой А ба Б ангилалд хамаарахгүй шатдаг, тэсвэрлэн шатдаг хатуу /тоос, хөвөнлөг материал орно/ шингэн бодис материал хэрэглэдэг үйлдвэрлэл.

4.2.4 Ангилал Г

Аюулын ангилал заагдахгүй үйлдвэрлэл – Боловсруулалтынхаа явцад дөл, оч болон дулаан ялгаруулдаг шатдаггүй бодис материалыг улайссан ба хайлмаг халуун хэлбэрт оруулан хэрэглэдэг, хатуу, шингэн, хийн хэлбэртэй бодисуудыг түлш болгон шатаах буюу ашигладаг үйлдвэрлэл.

4.2.5 Ангилал Д

Аюулын ангилал заагдахгүй үйлдвэрлэл – Шатдаггүй бодис материалуудыг хүйтэн байдалд хэрэглэдэг үйлдвэрлэл.

4.3 Гал унтраагуурын ангилал

4.3.1 Гал унтраах бодисын төрлөөр нь

- 4.3.1.1 Шингэн ба хөөсөн гал унтраагуур /Химийн, агаар механикийн хөөс, ус г.м./
- 4.3.1.2 Хийн гал унтраагуур /Шингэн хүүрс хүчлийн хий, аэрозолын, хүүрсхүчилбромтэтилийн г.м./
- 4.3.1.3 Нунтаг гал унтраагуур /ПСБ, ПС-1 маягийн хуурай нунтгууд/

4.3.2 Гал унтраах бодисын шатлагыг зогсоох аргаар нь

- 4.3.2.1 Хөргөх
- 4.3.2.2 Тусгаарлах
- 4.3.2.3 Сулруулах /шатах химийн урвалын явцыг сааруулах/
- 4.3.2.4 Саармагжуулах

4.3.3 Гал унтраах бодисын цахилгаан дамжуулах чанараар нь

- 4.3.3.1 Цахилгаан дамжуулдаг /ус, хөөс/
- 4.3.3.2 Цахилгаан дамжуулдаггүй /хий, нунтаг/

4.3.4 Хортой эсэхээр нь

- 4.3.4.1 Хоргүй /ус, хөөс, нунтаг/
- 4.3.4.2 Хор багатай /нүүрсхүчил, азот/
- 4.3.4.3 Хортой /3.5 ба 7 гэсэн бүрэлдэхүүнтэй фреонууд/

4.3.5 Гал унтраах бодисын хэмжээгээр нь

- 4.3.5.1 Бага оврын /5л хүртэл багтаамжтай/
- 4.3.5.2 Дунд оврын /5л-ээс 10л хүртэл багтаамжтай/
- 4.3.5.3 Зөөврийн болон суурин /10л-ээс дээш багтаамжтай/

5. Нийтлэг шаардлага

- 5.1 Яам, агентлаг, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн харьяа нэгж байгууллагын барилга, байгууламж өрөө тасалгаанд байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн төрөл, тоо хэмжээг барилгын гал тэсвэршилтийн

- зэрэг, үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, хэлбэр, технологийг харгалзан ашиглаж байгаа бодис материалын хэмжээ, физик, хими болон галын аюулын шинж чанар, тэдгээрт гарсан галын ямар бодисоор унтраах боломжтой, үнэт эд зүйлст гал унтраах бодис хэрхэн нөлөөлөх, өрөө тасалгааны талбай болон тоног төхөөрөмжийн тоо хэмжээ зэргийг тооцон энэ стандартад зааснаас багагүйгээр нарийвчлан тогтоож мөрдүүлнэ.
- 5.2 Объект, барилга байгууламжийг зураг төсөлд заасны дагуу галын автомат дохиолол, гал унтраах тоног төхөөрөмжөөр тоногдосон байна.
- 5.3 Галын дотуур крантгүй барилга, байгууламжид байгаа тэсрэх галын аюултай үйлдвэрийн газрууд, шатах материал их хэмжээгээр хуримтлагдсан задгай болон битүү агуулахад 50м^2 талбай бүрт 0.2м^3 багтаамж бүхий савыг усаар дүүргэн 2-оос доошгүй хувингийн хамт байрлуулах, эсвэл материалын хэмжээ, агуулахын талбайгаас шалтгаалан 10м^3 хүртэл батгаамж бүхий усан сан, ус сорох, шахах мотопомп, галын хоолой, хошуугаар тоноглоно.
- 5.4 Шатамхай тоос үүсгэх нөхцөл бүхий үйлдвэрлэлийн барилга байгууламж, тоног төхөөрөмж дахь шатамхай тоосонд нэмэхэд шаталт үүсгэдэггүй хатуу нунтаг, азот, хүүрсхүчлийн, хийн болон бусад инертийн хийг саармагжуулагчаар ашиглана.
Байвал зохих саармагжуулагчийн хэмжээг тухайн үйлдвэрлэлийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн эзэлхүүн, болзошгүй тоосжилтын хэмжээнээс шалтгаалан тогтооно.
- 5.5 “Д” ангилалд багтах өрөө, байрны талбай нь 100м^2 -аас ихгүй бол гал унтраагуур тавих шаардлагагүй.
- 5.6 Гал унтраах автомат төхөөрөмжөөр тоноглогдсон барилга байгууламж, өрөө тасалгаануудад талбайн хэмжээгээр тооцон гаргасан гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн байх нормын 50%-иас багагүй байрлуулан ашиглана.
- 5.7 Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг гал унтраах зориулалтаас бусад ажилд хэрэглэхийг хориглоно.
- 5.8 Гал унтраагуурууд болон бусад багаж хэрэгслийг шалны түвшингээс 1.5м-ээс дээшгүй зайд хүмүүсийн хөдөлгөөнд саад болохгүй авах, хэрэглэхэд хялбар дөхөм газарт, гал гарч болзошгүй газраас холгүй байрлуулна.
- 5.9 Галын саравчинд хамгаалж буй объектын галын аюулын байдал, талбайн хэмжээнээс шалтгаалан сүх, хүрз, дэгээ, хувин, царил, элстэй сав $/0.5\text{м}^3$ багтаамжтай/, эсгий болон галд тэсвэртэй бүтээлэг $/1\text{х}1\text{-}2\text{х}2\text{м}^2$ хэмжээтэй/ тус бүр 2ш-ээс багагүй байна.
- 5.10 Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг үйлдвэрлэгчийн техникийн нөхцөлд заасны дагуу тээвэрлэж хадгална.
- 5.11 Шинээр зохион бүтээсэн, импортоор оруулж ирсэн гал унтраагууруудыг худалдаанд гаргахын өмнө чанарын шаардлага хангаж байгаа эсхийг Галын шинжилгээний байгууллагаар шалгуулна.
- 5.12 Явуулын ба зөөврийн нэг удаа ашиглах зориулалт бүхий орон сууц, захиргаа, аж ахуй, олон нийтийн, үйлдвэрлэлийн, агуулахын барилга байгууламжид энэ норм хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 5.13 Агаарын, төмөр замын болон усан замын тээврийн хэрэгсэлд гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг тус бүрийн техникийн нөхцөлд нь заасан хэмжээгээр байрлуулна.
- 5.14 Байгууллага, аж ахуйн нэгж бүр галын анхан шатны багаж хэрэгслийн хадгалалт хамгаалалт, бэлэн байдал хариуцсан албан тушаалтныг томилж

- анхан шатны багаж хэрэгсэл нэг бүрийг хяналтын карттай болгож сар бүр үзлэг хийж чанар байдлын талаар тэмдэглэгээ хийнэ.
- 5.15 Ус, хөөсийг ашиглан гал унтраах зориулалттай гал унтраагуураар цахилгаан хэрэгсэл болон цахилгаан хүчдэл бүхий галыг унтрааж болохгүй.
- 5.16 Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл нэг бүрийн хяналтын карт

Байгууллагын нэр					
Багаж хэрэгслийн нэр төрөл, дугаар					
Сар	Чанар байдлын тэмдэглэл	Шалгасан албан тушаалтны гарын үсэг	Сар	Чанар байдлын тэмдэглэл	Шалгасан албан тушаалтны гарын үсэг
I			I		
II			II		
III			III		
IV			IV		
V			V		
VI			VI		
VII			VII		
VIII			VIII		
IX			IX		
X			X		
XI			XI		
XII			XII		

6. Объект, барилга байгууламжид байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн ерөнхий норм

Барилга байгууламжийн зориулалт	Үйлдвэрлэлийн ангилал, өрөө тасалгааны онцлог	Дунд/бага оврын гал унтраагуур		Зөөврийн болон суурин гал унтраагуур		Галын саравч /иж бүрэн/
		Хамгаалах талбай $/\text{м}^2/$	Тоо /аль нэг нь байна/	Хамгаалах талбай $/\text{м}^2/$	Тоо /аль нэг нь байна/	
1	2	3	4	5	6	7
Үйлдвэрлэлийн барилга	А	300	3/5*	1500	1	-
	Б	400	3/5*			-
	В	500	2/4*	-	-	-
	Г	1000	2/4*	-	-	-
Битүү агуулах	Д	1800	2/4*	-	-	-
	А	200	1/2*	1500	1	-
	Б	200	1/2*			-
	В	400	1/2*	-	-	-
	Д	1800	2/4*	-	-	-
	В,Г ангиллын үйлдвэрийн					

Захиргаа аж ахуйн барилга	барилга дотор таславч маягаар баригдсан өрөө тасалгаа	500	1/2*	-	-	-
	Бусад барилга, өрөө тасалгаа	500	2/4*	-	-	-
1	2	3	4	5	6	7
Олон нийтийн барилга	Сургалт хүмүүжил, соёл гэгээрэл, үзвэрийн барилга	800	3/6*	-	-	-
	Шинжлэх ухаан, олон нийт, аж ахуйн барилга	800	3/6*	-	-	-
	Эмнэлэг, амралт сувилал, спортын барилга	800	3/6*	-	-	-
	Худалдаа, нийтийн хоол, аж ахуйн үйлчилгээний барилга	800	3/6*	-	-	-
	Тээвэр, холбооны барилга	800	3/6*	-	-	-
	Олон зориулалттай барилга, өрөө тасалгаа	800	3/6*	-	-	-
	ШТС, Задгай агуулах, авто зогсоол бусад талбай	1800	2/4*	-	1	1
	Газар доорх болон газар дээрх авто зогсоолын барилга	400	2/4*	1500	1	-
	Жуулчны бааз	500	2/4*	-	-	1

* Тайлбар: 3/5 гэсэн тэмдэглэгээг 3 нь дунд оврын, 5 нь бага оврын заавал байх гал унтраагуурын тоо гэж ойлгоно.

7. Автомашинд байвал зохих гал унтраагуурын тоо

Автомашинны төрөл	Хийн ба нунтган гал унтраагуурын тоо	
	1л-ээс –л-ийн багтаамжтай	3л-ээс 5л-ийн багтаамжтай
Суудлын автомашин	1	-
Ачааны автомашин 4тн-оос 10тн-ын даацтай	-	1
10тн-оос дээш даацтай хүнд даацын автомашин	-	2
Автобус	-	1
Бензин шатахуун тээвэрлэх зориулалттай автоцистерн	-	2